



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН  
НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ  
ТОГТООЛ

2025 оны 01 сарын 20 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Иргэний хөдөлгөөний намын нэр, үндсэн  
дүрмийн өөрчлөлтийг улсын бүртгэлд  
бүртгүүлэх өргөдлийн тухай

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Ганзориг даргалж, Танхимын тэргүүн Г.Алтанчимэг, Ч.Хосбаяр шүүгч Б.Амарбаясгалан, Г.Банзрагч, Д.Батбаатар, С.Батдэлгэр, Н.Батзориг, М.Батсуурь, Х.Батсүрэн, Б.Батцэрэн, Н.Батчимэг, Н.Баярмаа, П.Золзаяа, П.Соёл-Эрдэнэ, С.Соёмбо-Эрдэнэ, Б.Цогт, Ц.Цогт, Х.Эрдэнэсүвд нарын бүрэлдэхүүнтэй хийсэн хуралдаанаар, Иргэний хөдөлгөөний намын нэр, үндсэн дүрмийн өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдлийг шүүгч Б.Амарбаясгалангийн илтгэснээр хэлэлцээд

ТОДОРХОЙЛОХ нь:

Иргэний хөдөлгөөний намын дарга Ө.Баяраагаас “Иргэний хөдөлгөөний намын нэрийг ИХ нам болгон өөрчилсөн, “Иргэний эрх” хөтөлбөрийг өөрчлөн шинээр найруулан “Нэгдмэл эрх зүйт Монгол хөгжил” болгосон, намын үндсэн дүрмийг шинэчлэн найруулан баталсан тул дээр дурдсан өөрчлөлтийг бүртгэж өгнө үү” гээд нийт 169 хуудас материал, 1 ширхэг флаш диск зэрэг холбогдох материалуудыг 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдөр Улсын дээд шүүхэд ирүүлсэн байна.

Дээрх өргөдөл, хавсралтаар ирүүлсэн баримтуудыг Улс төрийн намын тухай хууль болон Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 06 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан “Улс төрийн намын бүртгэл хөтлөх журам”-ын дагуу шалгаж, нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцэв.

ҮНДЭСЛЭХ нь:

Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаас дараах үндэслэлээр “Иргэний хөдөлгөөний нам”-ын нэрийг “ИХ” нам болгож өөрчилснийг бүртгэж, намын үндсэн дүрмийн өөрчлөлтийг бүртгэхээс татгалзаж шийдвэрлэлээ.

Нэг: Намын нэрийн өөрчлөлтийн тухайд:

1. Намын нэрийг өөрчлөх асуудал нь Иргэний хөдөлгөөний намын (2024 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн нэмэлт, өөрчлөлт) үндсэн дүрмийн 3 дугаар бүлгийн 1 дүгээр зүйлийн 1.1-д “ИХ” намын удирдах дээд байгууллага нь намын Их Хурал байна. “ИХ” намын Их Хурлыг “Иргэний Их Чуулган” ... гэж нэрлэнэ”, 2 дугаар зүйлд

“Иргэний Их Чуулганы бүрэн эрх”, 2.3-т “Намыг ... нэрийг нь өөрчлөх” гэж заасны дагуу тус намын удирдах дээд байгууллага болох Иргэний Их Чуулганы бүрэн эрхэд хамаарч байна.

2.Намын үндсэн дүрмийн 3 дугаар бүлгийн 1 дүгээр зүйлийн 1.5-д “Иргэний Бага Чуулганы гишүүдийн 55 дээш хувийн саналаар эсвэл намын Улс Төрийн Зөвлөлийн олонхийн саналаар ээлжит бус Иргэний Их Чуулганыг зарлан хуралдуулж болно” гэж заасны дагуу тус намын Улс төрийн зөвлөлийн хурлын 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор Иргэний хөдөлгөөний намын ээлжит бус Иргэний Их Чуулганыг 2024 оны 12 дугаар сарын 08-ны өдөр зарлан хуралдуулахаар шийдвэрлэсэн.

3.Намын Улс төрийн зөвлөлийн 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 09 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралтаар “Ээлжит бус Иргэний Их Чуулганы төлөөлөгчдийг сонгох журам”-ын 1.2-т “Хуралдаанд оролцох төлөөлөгчид 250-иас доошгүй байна” гэж тогтоосон. Ээлжит бус Иргэний Их Чуулган 2024 оны 12 дугаар сарын 08-ны өдөр хуралдаж, “ээлжит бус Иргэний Их Чуулганы хуралдааны бүрэн эрхийг баталгаажуулах тухай” 01 дүгээр тогтоол, тооллогын комиссын “Тооллогын дүнг батлах тухай” 01, 03 дугаар тогтоолуудаар Чуулганы хуралд оролцохоор мандат авсан 281 төлөөлөгчөөс 279 төлөөлөгч оролцсон тул хүчинтэй гэж үзэж, оролцсон нийт төлөөлөгчийн 100 хувийн саналаар намын нэр, үндсэн дүрмийн өөрчлөлтийг батлахыг дэмжсэн нь үндсэн дүрмийн 3 дугаар бүлгийн 1 дүгээр зүйлийн 1.4-т “... Иргэний Их Чуулганы төлөөлөгчдийн тоо нь 250-иас доошгүй байна”, 3 дугаар зүйлийн 3.1-д “Иргэний Их Чуулганд оролцвол зохих нийт төлөөлөгчдийн олонх нь хүрэлцэн ирснээр хурал хүчин төгөлдөр болох ба хуралд оролцогсдын олонхын саналаар Иргэний Их Чуулганы тогтоол хүчин төгөлдөр болно” гэж заасантай нийцжээ.

4.Намын ээлжит бус Иргэний Их Чуулганы 2024 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн “намын нэрийн өөрчлөлтийг батлах” тухай 09 дүгээр тогтоолоор Иргэний хөдөлгөөний намын нэрийг ИХ нам болгон өөрчилсөн нь Улс төрийн намын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Нам оноосон нэртэй байх бөгөөд түүний төгсгөлд “нам” гэсэн ерөнхий нэрийг заавал хэрэглэнэ”, 6.4-т “Намын бүтэн болон товчилсон нэр, бэлгэ тэмдэг нь төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага, сүм хийд, өөр хуулийн этгээд, бусад намын нэр, бэлгэ тэмдэгтэй давхардсан буюу бусдыг төөрөгдүүлэхээр ижил, төсөөтэй байж болохгүй”, 17 дугаар зүйлийн 17.2-т “Намын удирдах дээд байгууллага дараах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ”, 17.2.3-т “Намын нэрийг өөрчлөх, ... ” гэж заасантай болон тус намын үндсэн дүрэмд нийцсэн байх тул бүртгэх нь зүйтэй байна.

Өргөдөлд Өдрийн сонины 2024 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн №239 (7605) дугаарт намын нэрийг ИХ нам гэж өөрчилснийг зарлуулсан зар, хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалт зэрэг шаардагдах бусад баримтыг хавсарган ирүүлсэн болно.

Хоёр:Намын үндсэн дүрмийн өөрчлөлтийн тухайд:

1.Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д “намын үзэл баримтлал, үнэт зүйл, зорилго”-ийг намын дүрэмд

тусгахаар заасан, тус намын үндсэн дүрэмд намын үнэт зүйлийн талаар тусгаагүй, орхигдуулжээ.

2.Улс төрийн намын тухай хуулийн (цаашид “хуулийн” гэх) 15 дугаар зүйлийн 15.2.5-д “намын даргыг сонгох, чөлөөлөх, огцруулах, түүний бүрэн эрхийн хугацаа, эрх хэмжээ”-г намын дүрмээр тусгайлан тогтоохоор заасан, үүний дагуу намын даргыг “сонгох”, “чөлөөлөх”, “огцруулах” үндэслэл, шийдвэр гаргах журмыг намын дүрмээр тус тусад нь тодорхой заах шаардлагатай. Тус намын үндсэн дүрмийн 21 дүгээр зүйлд намын даргын бүрэн эрхийн хугацаа, эрх хэмжээг заасан хэдий ч намын даргад хэрхэн яаж нэр дэвших журам тодорхойгүй, түүнчлэн намын даргыг чөлөөлөх, огцруулах үндэслэлийг тодорхой нэрлэн заагаагүй нь хуулийн дээрх шаардлагыг хангахгүй байна.

3.Хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.8-д “төрийн улс төрийн албан тушаалд болон намын удирдах албан тушаалд нэр дэвшигчийг сонгох, томилох, чөлөөлөх, тэдгээрт жендерийн тэгш байдлыг хангах журам”-ыг намын дүрмээр зохицуулахаар заасан ч “томилох”, “чөлөөлөх” үндэслэлийг заагаагүйгээс гадна мөн хуулийн 15.2.10-т заасан “намын салбар болон бүтцийн нэгжийг байгуулах, татан буулгах үндэслэл, журам”-ыг тодорхой тусгаагүй.

4.Хуулийн 27 дугаар зүйлийн 27.13-т “Төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгийг сонгуулийн төв байгууллагын шийдвэрийн дагуу намын төв байгууллагад олгох бөгөөд салбар болон бүтцийн нэгжид хуваарилах асуудлыг намын дүрмээр зохицуулна” гэж заасан. Харин намын үндсэн дүрмийн 38.3-т “Төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгийг намын дансанд хүлээн авах ба намын салбар болон бүтцийн нэгжид хуваарилах асуудлыг Улс төрийн намын тухай хууль, холбогдох журамд нийцүүлэн намын Улс төрийн зөвлөл шийдвэрлэнэ” гэсэн нь тодорхой бус, Улс төрийн зөвлөл нь намын салбар болон бүтцийн нэгжид төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгийг хэрхэн яаж хуваарилах талаар дүрэмд тодорхой тусгах шаардлагатай.

5.Хуулийн 42 дугаар зүйлийн 42.4-т “Энэ хуулийн 42.1-д заасан арга хэмжээг авахад хүргэсэн алдаа, зөрчлийг намын орон нутгийн салбар нэгж гаргах тохиолдолд зохицуулах заалтыг нам дүрэмдээ тусгана” гэснийг намын дүрэмд тусгаагүй байна.

6.Намын үндсэн дүрмийн 18 дугаар зүйлийн 18.5-д “Бага чуулган энэ дүрмийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь заалтад нийцүүлэн бүрэн эрхээ хэдэн гишүүний бүрэлдэхүүнтэй хэрэгжүүлэхийг намын үйл ажиллагааны цар хүрээ, цаг үеийн хэрэгцээ шаардлага, бусад үндэслэлийг харгалзан өөрөө тогтоож болно” гэж, 18.8-д “Их чуулганы чөлөөт цагт энэ дүрмийн 18 дугаар зүйлийн 18.7-д заасны дагуу Бага чуулганы орон гарсан гишүүний оронд нөхөн батламжлах эрхийг Бага чуулган өөрөө хэрэгжүүлнэ. ...” гэж, 19.8.3-т “намын Их чуулганы чөлөөт цагт энэ дүрмийн 18 дугаар зүйлийн 18.3-т заасны дагуу Бага чуулганы орон гарсан гишүүний оронд нөхөн сонгох, нөхөн батламжлах” гэж намын Бага чуулганд эрх олгосон нь намын Удирдах дээд байгууллага буюу Их Чуулганы бүрэн эрхтэй давхарджээ.

7.Хуулийн 17 дугаар зүйлийн 17.5-д “Намын дүрэмд заасны дагуу намын удирдах дээд байгууллага, эсхүл төлөөллийн төв байгууллага нь намын гүйцэтгэх

төв байгууллагыг дөрвөн жилээс илүүгүй хугацаагаар сонгоно. Гүйцэтгэх төв байгууллага нь гурваас доошгүй тооны гишүүнтэй байна” гэж, намын үндсэн дүрмийн 19 дүгээр зүйлийн 19.8-д “Бага чуулган дараах бүрэн эрхтэй”, 19.8.7-д “намын даргын санал болгосноор Улс төрийн зөвлөлийн гишүүдийг 4 жилийн хугацаагаар сонгох, чөлөөлөх ...” гэж гүйцэтгэх төв байгууллагын гишүүдийг “намын даргын санал болгосноор сонгох, чөлөөлөх”-өөр үндсэн дүрэмд тусгасан нь хуульд нийцэхгүй байна.

8.Намын үндсэн дүрмийн 39 дүгээр зүйлийн 39.1-т “Намын гишүүний болон сонгуульт гишүүний нэг сарын татварын хэмжээг Улс төрийн намын тухай хуульд нийцүүлэн намын Улс төрийн зөвлөл батална” гэсэн нь хуулийн 32 дугаар зүйлийн 32.1-д “Гишүүний татварын хэмжээ, бүрдүүлэлтийг тухайн намын дүрмээр тогтооно” гэж заасанд нийцээгүй, намын дүрэмд намын гишүүний татварын хэмжээг тодорхой заах нь зүйтэй.

9.Хуулийн 41 дүгээр зүйлийн 41.3-т “Энэ хуулийн 41.1-д заасан арга хэмжээг авахад хүргэсэн алдаа, зөрчлийг намын орон нутгийн нэгж гаргасан тохиолдолд тухайн асуудлыг нам дүрмээр зохицуулна” гэсэн дүрмээр зохицуулах асуудлыг тодорхой заагаагүй.

Иймд Иргэний хөдөлгөөний намын үндсэн дүрмийн өөрчлөлтийг бүртгэх боломжгүй, тус нам нь өөрийн үндсэн дүрэмд заасан журмын дагуу дахин хуралдаж, дээрх зөрчлүүдийг арилгасны үндсэн дээр Улс төрийн намын тухай хуульд нийцүүлэн намын дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг шинэчлэн баталж, хуульд заасан хугацаанд Улсын дээд шүүхэд дахин хандах эрхтэй болохыг дурдаж байна.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.8, 26 дугаар зүйлийн 26.1-д заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Улс төрийн намын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 17 дугаар зүйлийн 17.2.3-т заасныг тус тус баримтлан Иргэний хөдөлгөөний намын нэрийг ИХ нам гэж өөрчлөн бүртгэсүгэй.

2.Улс төрийн намын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5-д заасныг баримтлан Иргэний хөдөлгөөний намын үндсэн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг бүртгэхээс татгалзсугай.

3.Өргөдөл гаргагчаас улсын тэмдэгтийн хураамжид төлсөн 150,000 (нэг зуун тавин мянга) төгрөгийг улсын орлогод хэвээр үлдээсүгэй.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,  
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.ГАНЗОРИГ

ИЛТГЭГЧ ШҮҮГЧ

Б.АМАРБАЯСГАЛАН